

**ТҮШЭЭ ГҮН ЧАГДАРЖАВ БА ХЯТАД,
ОРОС, МОНГОЛ ГУРВАН УЛСЫН
1915 ОНЫ ХИАГТЫН ГЭРЭЭ**

О.БАТСАЙХАН

Түшээ гүн Чагдаржавын намтарт холбогдох
зарим мэдээ

Түшээ гүнгийн гарал удамыг шашдир түүхээс мөшгин үзэх аваас Чингис хааны 31 дэх үе Батмөнх даян хааны отгон хөвгүүн Гэрсэнз жалайр хун тайжийн залгамжир, Норов эрх ахайн хөвгүүн Лидэрийн 7 дахь үе, Гадинбалын хүү болон Түшээт хан аймгийн говь Түшээт вангийн хошуу одоогийн Дундговь аймгийн Дэлгэрхангайн нутагт 1870 аад оны дунд үеэр төржээ. Бадаргуулт төрийн 21 дүгээр он 1896 онд эцэг Гадинбал таалал төгссөн тул Чагдаржав эцгийн хошуу захирагчийн тушаалыг гардан авч төрийн үйл хэрэгт анх оролцох болжээ. 1900 онд Түшээт хан аймгийн чуулган дэд даргын тушаалд томилогдож, улмаар 1909 онд Халхын үндсэн 4 том аймгийн нэгэн болох ба нөлөө бүхий аймгийн чуулган даргаар сонгогджээ.

Тэрээр чуулган дарга болуут өөрийн төрж өссөн Дэлгэрхангай уулынхаа ард нутаглах өргөөнийхөө дэргэд жасаагаа нүүлгэн аваачсан тухай мэдээ бий.¹

Түүний төрсөн оны талаар тодорхой баримт олдохгүй байгаа хэдий ч 1870 аад оноос 1915 оны хооронд амьдарч байсан тухай мэдээ бий. Гадинбалын Чагдаржав Түшээт хан аймгийн Говь Түшээт вангийн хошууны засаг ноён, Түшээт хан аймгийн чуулган дарга, 1911 оны Монголын үндэсний хувьсгалын үйл хэрэгт онцгой идэвхтэй оролцож, Үндэсний хувьсгалыг санаачлан удирдагчдын нэг юм. Тэрээр үндэсний эрх чөлөөний төлөө тэмцлийн үйл хэргийг анх сэдсэн Нүхтийн амны зөвөлгөөнд оролцож, 1911 оны арван нэгдүгээр сарын 30нд байгуулагдсан “Халхын Хүрээний бүх хэргийг түр ерөнхийлэн шийтгэх газрын” анхны даргаар ажиллаж байсан. Сангийн яамны тэргүүн сайд, түшээ гүн. Хүрээн дэх Оросын консул 1912 оны 4 сарын 12 нд мэдээлэхдээ: “Хүрээнд Оросын худалдаачдын санаачилгаар Орос монголын нөхөрлөл” хэмээхийг байгуулж, түүнд санаачлагч оросын худалдаачдаас гадна монголын дөрвөн сайд орсон (Да лам, Ханддорж, Түшээт ван, Намсрай)” гэжээ.² Энэ талаар Котвич тодруулан энэ

¹ О.Батсайхан, ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D), дэд профессор

нөхөрлөлд “Сайд Чагдаржав орсоныг” бичсэн байдаг. Үүнээс үзвэл Түшээ гүн Чагдаржав Орост ээлтэй хүн байсан болов уу. Тэрээр 1915 оны Хиагтын хэлэлцээрт Монгол улсын Засгийн газрын бүрэн эрх барих төлөөлөгчөөр томилогдон оролцсон бөгөөд хэлэлцээр 1915 оны 6 сарын 7 нд дуусмагц Хүрээнд буцаж ирээд нэг сар орчмын дараа сэжиг бүхий байдлаар гэнэт нас барсан мэдээ бий.

Г.Чагдаржавын улс төрийн үйл ажиллагаанаас

Түшээт хан аймгийн чуулган дарга Чагдаржав язгуураас Монгол төрийн дээдсийн удам болох бол Монголынхоо тусгаар тогтнол, эрх чөлөөний төлөө хэмээсэн сэтгэл ямагт өвөрлөж, манжийн төрийн монголын талаар явуулсан бодлогыг, тухайлбал шинэ засгийн бодлогыг эсэргүүцэж, 1910 оны намар цаг Хүрээ, Улиастайн сайдад бичиг шийтгэн мэдүүлэхдээ: «Манж улсаас зарлан тушаасан шинэ засгийн хэрэг зүйл нь монголчуудад үлэмж харштай болохыг тэмдэглэж, «манай монгол газар дор тариа нэмэн хагалах ба газар тэгшилж үр хуваарийн хэмжээгээр гааль хураалгах хэмээсэн хэргийг бүрнээ хэлтрүүлж» «бидний монголчууд эртний цагаас нааш хөдөө газарт дөрвөн зүйлийн мал адуулж, нутаг бэлчээрийг эрхлэн мах шимийг идэж хэрэглэж» ирсэн «монголчуудын аж төрүүлэхийг хүндэтгэхийг» хүссэн байдаг.³ Энэ нь тэрээр Монголынхоо уламжлалт зан заншил, үндэс угсаа манжийн шинэ засгийн бодлогын үрээр алдагдагдах аюул тулгарч ирснийг ийнхүү мэдэрч эсэргүүцлээ илэрхийлсэн хэрэг байлаа.

Хэвт ёсны 2 дугаар онд жил бүр болдог Богд Жавзандамба ламтнаа бат оршил өргөх баярын ёслол үйлдэх үеэр Богд ламтнаас «одоо бол манж улсын тоо улирал дуусч, засаг төр мөхөх цаг хэмжээ болсон бөгөөд манай монгол, олон аймаг бүгдээр сэтгэл хүчийг нэгтгэн цаг зүйд тохиолдуулан явбал тусгаар улс төрийг байгуулан бүтээж болно» гэсэн нууц зарлиг заавар гарсаны дагуу Халхын түшээт хан аймгийн жанжин Эрдэнэ дайчин чин ван Ханддорж, чуулганы дарга Түшээт ван Чагдаржав, эрдэнэ ван Намсрай, Сэцэн хан аймгийн жанжин Эрдэнэ далай ван Гомбосүрэн, их шавийн Да лам Цэрэнчимэд нарын таван хүн Богд хан уулын ард модон дотор сэмжэнээ хуралдан «..Монгол олон аймаг Манж улсаас салж тусгаар улс төрийг байгуулан тогтооход алс одоогийн алдах онох ашиг хохирол тус хор амгалан зовлонгийн учрыг дахин давтан бодолгоож боловсортол хэлэлцэж» Монголынхоо тусгаар тогтнолын төлөө тэмцлийн эх суурийг тавьжээ.⁴

Эх орноо хэмээсэн ноёдын хурлаас өөрийн үндэсний тэмцэлд Орос улсаас дэмжлэг авах зорилгоор Ханддорж, Цэрэнчимэд нарыг Хаант Орост нуудаар илгээх шийд гаргажээ. Манж сайд Саньдо уг хэргийг сонсоод Түшээт ван Чагдаржав, далай ван Гомбосүрэн нарыг

байцаахад тэд илэрхийгээр мэлзэн харин ч хариу «танай Манж улсын дотоод мужид самуун намын хувьсгал гарч улс төр чинь туйлын түгшүүртэй болсон тул манайх нилээд цэрэг бэлтгэлээ, сайд та бидэнд цэрэг, зэвсэг зүйлийг гаргаж өгнө үү» гэх зэргээр сүрдүүлэн эсэргүүллээ илэрхийлжээ.⁵ Чагдаржав, Ханддорж хоёул нэгэн аймгийн жанжин, чуулган даргын албыг хашиж, үзэл бодол, санаа зорилго нэгтэй болсон нь хамтаар үндэснийхээ тусгаар тогтнол, эрх чөлөөний төлөө тэмцлийг санаачлан тэргүүлж оролцоход дөхөмтэй байсан буй за. Тиймээс 1911 оны үндэсний хувьсгалын эхэн үеийн ихэнх баримт бичгүүдэд Чагдаржав, Ханддорж нарын нэр ихэвчлэн хамтдаа бичигдсэн байхыг олонтаа харж болно.

Чагдаржав ба 1911 оны Монголын үндэсний хувьсгал

1911 оны 11 сарын 30нд Халхын хүрээний бүгд хэргийг түр ерөнхийлэн шийтгэх газрыг Чагдаржаваар тэргүүлүүлэн 7 хүний бүрэлдхүүнтэй байгуулжээ. Чагдаржавын тэргүүлсэн Халхын хүрээний бүгд хэргийг түр ерөнхийлэн шийтгэх газар Монголын нутгаас манж тэргүүтэй харийн түрэмгийлэгчдийг хөөн зайлуулж, Үндэснийхээ тусгаар тогтнолоо сэргээн мандуулж төр улсаа төвхнүүлэх үүргийг амжилттай гүйцэтгэсэн билээ.⁶ Энд Чагдаржавын оролцоо ямагт тэргүүлэх байр суурьтай байсаныг цохон тэмдэглэх учиртай. Монголын үндэсний тусгаар тогтнолыг сэргээн мандуулах 1911 оны үндэсний хувьсгалыг манлайлан удирдагчдын нэг яах аргагүй Чагдаржав мөн билээ. Түүний Монголын тусгаар тогтнолын төлөө гүйцэтгэсэн үүргийг тэр бүр түүхэнд тэмдэглсэн нь ховор бөгөөд түүний түүхэнд эзлэх байр суурийг өнөө хэр тодорхойлсон дорвитой бүтээл үгүйлэгдэж байгааг дурьдах нь зүйтэй байх.

Монголын тулгур төрийг нээн байгуулах их үйл хэргийг зохион байгуулагчдынхаа хувьд Халхын Хүрээний газрын бүгд хэргийг түр ерөнхийлэн захиран шийтгэх түшээ гүн Чагдаржав, хамаарсан да жун ван Гомбосүрэн, зөвлөн шийтгэх туслагч жанжин чин ван Ханддорж хамаарсан жанжин бэйс Гомбосүрэн, гүн Намсрай, да лам Цэрэнчимэд нар хамтран Халхын аймгийн чуулган дарга нарт бичиг шийтгэж, «Энэ жил өвлийн дунд сарын шинийн ёсонд Очирдарь Богд гэгээнтэнийг Монгол улсын Богд эзэн хаанд өргөмжилж эрдэнийн сууринд залж суулгах», «мөнхүү өдөр улс төрийг тулгур зохиож Дотоод яамны зэрэг таван яамыг байгуулах» -ад зориулан Халхын дөрвөн аймгаас хошоод түмэн лан цагаан мөнгийг бүрэн гаргуулж, улс төрийн хүү сан болгоход бэлтгүүлдсүгэй. Энэ болбоос сан хөмрөгт холбогдсон чухал хэрэг мөн» хэмээн тэмдэглэж байжээ.⁷

Олноо өргөгдсөний тэргүүн оны өвлийн дунд сарын шинийн 9-

ний өдөр “Богдыг Монгол Улсын наран гэрэлт, түмэн наст Богд эзэн хаан, Цагаан дарь эхийг Улсын Эх дагина хэмээн өргөмжлөн, эрдэнийн сууринд залж суулгаад, оны цолыг Олноо өргөгдсөн, Их Хүрээг Нийслэл Хүрээ хэмээн нэрлэсэн, дундаа соёмбо үсэгтэй шар торгоор хийсэн төрийн далбаа бүхий Монголын тулгар төр нээсэн тухай”⁸ даяар олноо тунхаглан зарласан билээ. Эл өдөр Богд хаан “Би олны өргөмжлөхийг хүлээж Монгол улсын хааны сууринд суусан нь бурханы шашиныг буман нараны гэрэл мэт хир үгүй мандуулан хаан төрийг сүмбэр уул мэт бат болгож олон монгол албатыг үүрд энх түвшиний соёлд учирлуулахыг үргэлжид шамдан хичээхийн дээр ялангуяа танай олон хан ван ноёдоос дараалан түмэн албат хүртэл төв шударга хичээнгүй үнэнийг сүслэн эрхэмлэж бүгд нэгэн сэтгэлээр шашин төрд сайнаар зүтгэхийг тус тус ухуулан» хишиг тархаан буулгасан зарлигтаа: «Тулгур төр байгуулах тухайн хэрэгт онц хүчин зүтгэж «үнэн санаагаар чармайн зүтгэсэн Түшээт хан аймгийн засаг улсын түшээ гүн Чагдаржавт үе улиран Түшээт цол, засаг төрийн жүн вангийн хэргэм, шадар сайд, Сангийн хамаг хэргийг бүгд захиран шийтгэгч яамны тэргүүн сайдаар» тохоон томилж, түүнд «4 үзүүрт чандмань бариул бүхий 4 пүү, 3 ямх мөнгөн тамга бариулан шагнажээ.»⁹

Г. Чагдаржав - Монгол улсын Сангийн яамны анхны тэргүүн сайд

Богдын зарлигийн дагуу шагнагдсан төрийн сайдууд, түүний дотор Чагдаржав «дотоодод болбоос тус тусын үнэн шударгыг илэрхийлэн .. бэрхээс зайлахгүй, энэхүү батлан тогтоосон тангараг сахилгыг нүдний цөцгий, зүрхний тольт мэт хичээнгүйлэн хайрлана»¹⁰ хэмээн төр улсдаа үнэнчээр зүтгэхээ илэрхийлжээ. Чагдаржав төрдөө өргөсөн тангарагтаа чин үнэнч байж өөрийн үлдсэн амьдралаа эцэслэн дуустал Монголынхоо төлөө зориулсан билээ. 1911 оны үндэсний хувьсгалын үр дүнд тусгаар тогтнол, эрх чөлөөгөө олж авсан нь маш том амжилт байсан хэдий ч монголын төрийн зүтгэлтнүүдийг төр улсаа төвхнүүлэх, улсын дотоод, гадаад бүхий л хэргийг өөд нь татах том ажил хүлээж байлаа. Энэ үеийн Монголын байдал гэвэл, хувиа аргацаасан мал аж ахуйтай, үндэсний үйлдвэрлэл хөгжөөгүй, худалдаа, үндэсний мөнгөн тэмдэгт жинхэнэ ёсоор хөгжөөгүй, үндэсний боловсон хүчин дутмаг, санхүүгийн үндэсний систем бүрэлдэн тогтож чадаагүй ийм дүр төрхтэй улс орон байлаа. Иймээс эл бүхнийг даван туулж, санхүүгийн үндэсний систем бий болгох амаргүй зорилт Шинэ тулгур Монгол улсын Засгийн газар, түүний Сангийн тэргүүн сайдын өмнө тулгарсан юм. Сангийн тэргүүн сайд Чагдаржавын оролцоотойгоор юуны өмнө Манжийн албан гувчуур төлөх явдлыг бүр мөсөн таслан

зогсоож, хятадын худалдаа, мөнгө хүүлэгчдийн дураар аашилах явдлыг хязгаарлаж эхэллээ. Шинэ тулгур Монгол улсад эдийн засаг, нийгмийн наад захын алхмууд хийхийн тулд санхүүгийн эх үүсвэр үнэхээр чухал байлаа. Иймээс гадаадын аль нэгэн орноос мөнгө зээлэх явдал зайлшгүй шаардлагатай байв. 1644 оноос хойш Манжийн эрхшээлд байсан хятадууд 1911 онд манжаас салж, тусгаар тогтнолоо сэргээхдээ Монголчууд бол хятадын нэгэн хэсэг хэмээсэн бодлого баримтлах болсон тул Монгол улс Хятадаас мөнгөн зээл авна гэж бодох хэрэггүй байв. Иймээс Монголын тусгаар тогтнолыг дэмжиж байсан цорын ганц орон болох Хаант Оросод Монголын Сангийн тэргүүн сайд Чагдаржав удаа дараа хандан хүсэлт тавьж байв. Үүний үрээр 1912 оны 5 дугаар сард нэг зуун мянган рублийн зээлийг Орос улсаас авч, улсын санхүүгийн эх үүсвэр болгон үндэсний арми зохион байгуулах, байгалийн баялаг ашиглах зэрэгт зарцуулж байжээ. Улмаар 1912 оны 10 сарын 21 нд Нийслэл хүрээнд Монгол Оросын найрамдлын гэрээ, ба худалдааны протоколд Оросын Монгол дахь консул И.Коростовец Монголын Засгийн газрын ерөнхий сайд, бусад сайдуудын хамтаар гарын үсэг зурсан юм. Эдгээр сайдуудын дотор Сангийн яамны тэргүүн сайд Чагдаржав орсон байдаг. Эл хэлэлцээрээр монгол, оросын эдийн засаг санхүүгийн хамтын ажиллагааны ерөнхий журмыг тодорхойлсон билээ. Мөн түүнчлэн эл хэлэлцээр нь шинэ тулгур Монгол улсын хувьд Хаант Орос улстай бие даан байгуулсан анхны хэлцэл төдийгүй, Монголын тусгаар тогтнолыг, түүний Засгийн газрыг хүлээн зөвшөөрөх улс төрийн чухал ач холбогдолтой баримт бичиг байсан юм. Иймээс эл хэлэлцээрийн талаар Хятадын Гадаад хэргийн сайд Бээжинд сууж байсан Оросын элчин лугаа ярихдаа, эл гэрээгээр оросууд Монголын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрчихлөө хэмээн мэдэгдсэн байдаг.¹¹

1913 оны 1 сарын 15 нд Монгол улсын ерөнхий сайд Намнансүрэн, Сангийн сайд Чагдаржав нар Хаант Орос улсын консул И.Коростовец лугаа найман зүйлийн гэрээ байгуулж, хоёр сая шельковыг 20 жилийн хугацаатай зээлдэн авахаар тохиролцсон байдаг.¹² Ийнхүү шинэ тулгур Монгол улсын санхүүгийн эх үүсвэр, үндэсний систем бий болгоход оруулсан Чагдаржавын хувь нэмэр их билээ.

1911 оны Монголын үндэсний хувьсгалын дараа Монголын өмнө хязгаар Өвөр Монголд хятадууд цэргийн хүчээр түрэмгийлэл үйлдэж байсан тул Монголын засгийн газраас цэрэг илгээсэн бөгөөд энэ тэмцэлд Чагдаржав цэрэг удирдан оролцсон ажээ.¹³ Иймээс ч түүнд Богд хааны зарлигаар «олон монголчуудыг илбэн тохинуулах ажилд явахуйд элдэв хэрэг зүйлийг зүй ёсоор шийтгэн явсан тул зарлигаар «Чин вангийн» зэргэ шагнан хүртээж байжээ.¹⁴

Г. Чагдаржав ба Гурван улсын Хиагтын гэрээ

Г. Чагдаржав Хятад, Орос, Монгол гурван улсын 1915 оны Хиагтын хэлэлцээрт Монголын засгийн газрын бүрэн эрх барих төлөөлөгчөөр томилогдон ажилласан. Монголын засгийн газар энэхүү хэлэлцээрт хоёр яамны тэргүүн сайдаа засгийн газрыг төлөөлөх эрхтэйгээр томилон явуулсаны нэг нь Сангийн яамны тэргүүн сайд түшээ гүн Гадинбалын Чагдаржав бүлгөө.

Монголын төлөөлөгчдийн тэргүүн Дашжав, Чагдаржав нар Оросын бэлтгэсэн албаны хэлэлцээрийн газар очиход, Оросын бүрэн эрх барих элчин генеральный консул сайдаас: Их Думдад иргэн улсын бүрэн эрх барих төлөөний хүн нар ба Монгол засгийн хэрэг шийтгэх газрын бүрэн эрх барих төлөөний хүн бид нар энэ өдөр энд чуулж гурван этгээдийн найрамдлыг илэрхийлсэн тул уул хэргийг найрамдалаар хэлэлцэн тогтоож гайхамшигтай алдрыг бичиг шашдир дор үлдээхийг гүнээ эрмэлзмүй хэмээн хэлжээ. Харин Хятадын бүрэн эрх барих төлөөний хүн Би Гуй Фан: Думдад улс ба Монгол уулаас нэгэн гэр бүлгөө. Гагцхүү мөнөөхөн Думдад улс засгийн байллыг халсан тухай дор Хүрээ нийслэл хотоос алсалсан нь хол бөгөөд нарийн учрыг нэвтрэн эс мэдсэн учир Гадаад Монгол гагцаар тогтнохуй дор хүржээ хэмээн өөрийн бодлыг тулгаж эхэлсэнд Монголын төлөөлөгч Дашжав, Чагдаржав нар эл асуудлыг хэлэлцэхийг түр хэдэн өдөр алгуурласугай хэмээсэнээр эхний өдрийн хуралдаан маш товчхон болж өнгөрчээ.¹⁵ Хэдийгээр харилцан танилцах маягтай эхлэл байсан боловч хятадуудын баримтлах байр суурь үндсэндээ тодорхой харагдаж байжээ.

Иймээс Монголын төлөөлөгчдийн тэргүүн Түшээт ван Чагдаржав Оросын элчин консул лугаа уулзахад тэд Монголын Оросын хооронд байгуулах Дөрвөн зүйлийн гэрээний асуудлыг хөндөж тавьсан байна. Энэ нь Төмөр замын гэрээ, Төмөр утсаны гэрээ, Буу зэвсгийн гэрээ ба мөнгөний гэрээнүүдийг хэлж байв.

Монголын төлөөлөгчид: Бид нар даруй Засгийн газар лугаа зөвшилцөж, хариу өгмүү хэмээн хугацаа алгуурласад Оросын төлөөлөгчид ихэд уурсаж: Энэ дөрвөн гэрээг одоо дээр үл тогтоовоос элдэв дор хойч дор гомдолгүй буй за... Та нар Хятад дор дарлагдахыг өөрснөө дурлах тул манай Орос улс дор битгий гомдогтун. Хэрхэхээ дөрвөн өдрийн дотор эрх үгүй тодорхойлон хариу хэлтүгэй хэмээн шахаж шаардаж байжээ.¹⁶

Олноо өргөгдсөний 4 он 8 дугаар сарын 4-ний өдөр Хиагтад Оросын Засгийн газраас шаардсанаар Орос-Монголын хооронд мөнгө зээлдүүлэх, буу зэвсгийн, төмөр зам байгуулах, цахилгаан мэдээ байгуулах тухай гэрээнүүд нууцаар байгуулж, Дотоод яамны тэргүүн сайд Дашжав, Сангийн яамны тэргүүн сайд Чагдаржав нар гарын үсэг зурсан байдаг.

Эл дөрвөн гэрээний эхнийнх нь «Их Орос улсын хаан эзний засгийн газраас Монгол засгийн газар зээлдүүлэн өгөх гурван зуун түмэн цаасны тухай» байсан бөгөөд эл мөнгийн хүүгүй зээл өгөх ба зээлэн авсан мөнгийг Монгол Засгийн газраас санхүүгийн эх үүсвэрийг сайжруулах, дотоодын аливаа зүйлийг засах ба газрын баялгийг ашиглах, мал сажруулах, орос монгол багш нараар цэрэг боловсруулах, цэргийн хэрэгслийн зэрэг тустай явдалд зарцуулахаар заасан байна. Чагдаржавын гарын үсэг зурсан дараах гэрээ нь Их Орос улсын хаан эзний засгийн газраас Монгол засгийн газарт үхэр буу зургаа, мөн бууны сум гурван мянга, пулемёт буу дөрөв, мөн бууны сум дөчин түм, винтов буу хоёр түм, мөн бууны сум хорин саяыг өгөх тухай гэрээ байв. Түүний байгуулсан удаах гэрээ нь Монгол улсын төмөр замуудыг Орос улсын ойр бүхий төмөр замууд лугаа холбож бататгах, зохистой төмөр зам тавих тухай байв. Мөн бас нэгэн гэрээ нь Их Орос улс болон Улиастай, Ховдоос Монгол улсын Нийслэл Хүрээний хооронд мэдээ авалцахыг хялбар болгох үүднээс Монд Улиастай хоёрын хооронд цахилгаан мэдээ байгуулах тухай гэрээ байв. Эдгээр гэрээнүүд нь Монгол улсын тулгур төрийг бэхжин хөгжихэд дэмжлэг үзүүлэх ёстой байлаа. Иймээс ч Чагдаржав дээрх асуудлуудад ихээхэн анхаарал тавьж, хэдийгээр гэрээний зарим заалт Оросын талд давуу эрх өгч байсан хэдий ч гурван улсын гэрээний үеэр Орос улс Монголын тусгаар тогтнолын асуудлыг тодорхой хэмжээнд дэмжинэ байх гэсэн найдвар өвөрлөж байсантай холбоотой юм.

Хэлэлцээрийн эхний өдрүүдэд Монгол, Оросын хооронд дөрвөн зүйлийн гэрээ тойрсон яриа өрнөж байх хооронд Хятадын төлөөлөгчдөөс Гурван улсын хэлэлцэх асуудлыг нарийвчлан тогтох санал дэвшүүлж байлаа. Хятадын элчингээс:

Орос, Хятад хоёрын тогтоосон гэрээг дагах учир сая энэ хурлыг нээсэн. Эс дагах аваас бид нар ирэх үгүй бөгөөд Гадаад Монголын газар манай Думдал улсын нэгэн хэсэг газар болох тул дэмий тэмцэлдсэн үгүй болбу хэмээн санасан бүлгөө хэмээж өөрөөр хэлбэл гурван улсын хэлэлцэх асуудлын хүрээ 1913 оны Орос Хятадын тунхагаас гажих ёсгүй хэмээсэн байр суурийг илэрхийлж байв.

Үүний хариуд Монголын элчин төлөөлөгчдийн тэргүүн Чагдаржав: Олноор өргөмжлөн хаан эзний суурин дор залж айл Орос улс зөвшөөрөн хүлээсэн учир гэрээ бичиг тогтоон нэгэнт тусгаар улс болж дөрвөн жил болсон бөгөөд бүх монгол харьяат газар орноо бүрнээ нэгтгэн авахыг хүсч буй учирт энэ өгсөн бичгээр болбоос хүлээн хэлэлцэж огт чадах үгүй. Харин айл улсын ёсоор хэн алиндаа харшлал үгүйгээр худалдаа нэвтрүүлэх найрамдлын гэрээ бичиг байгуулах учрыг хэлэлцсүгэй хэмээж, хэлэлцээрийн асуудал, хүрээ 1912 оны Орос Монголын тогтоосон найрамдлын гэрээний дагуу явах учиртайг тайлбарлаж байжээ.¹⁷

Хиагт хотноо 1914 оны наймдугаар сарын 26-нд (европийн хуучин тооллоор –О.Б) ажлаа эхэлсэн Хятад, Хаант Орос, Гадаад Монгол гурван этгээдийн хэлэлцээрийн бага хурал нь Хятад, Орос хоёрын хуйвалдааны эсрэг үндэс, угсаа, тусгаар тогтнол, эрх чөлөөгөө хамгаалан бэхжүүлэхийг эрхэмлэгч – Монголын эх орончдын тэмцлийн нэгэн томоохон хэлбэр байсан юм. Энэ бол ядаж хадны дунд хавчуулагдсан халиуны зулзага байхын төлөө “улс төрийн их хэргийг осолдон омтгойтох буюу хайш яйшаар алдахад хүргүүлвээс гэмшивч бээр гүйцэхгүй болмой”¹⁸ гэсэн итгэл, сэтгэл өвөрлөсөн Чагдаржав нарын Монголын бүрэн эрхт төлөөлөгчдийн тэмцэл төдий бус Хүрээ, Улиастай, Ховд, Алтанбулаггүй эрх чөлөөт цэнхэр тэнгэртээ залбирал үйлдэн тэмцсэн монгол ард түмний 270 гаруй өдөр, шөнө байсан юм.

Чагдаржав нар Хиагтаас тоон кодоор Ерөнхий сайд Намнансүрэн тэргүүтэй засгийн газрынхан лугаа цахилгаанаар холбоо барьж, санал солилцон хэлэлцэж байсан нь архивиас тодхон харагдана.

Хятадын эрх барьсан төлөөлөгч Монголын тусгаар тогтнолыг үл зөвшөөрөн, Монголын Хааны болон улсын цол, Олноо өргөгдсөн он тоолол зэргийг өөрчлөх явдлыг хэлэлцээрийн зайлшгүй нөхцөл болгон тавьж, “Харьяат захирах нэгэн хувийн доторх өөрийгээ засах газар орон дор улс буй болж үл болмой. Засгийн газар буй болж үл болмой. Мөн хааны цол буй болж үл болмой”¹⁹ хэмээн эсэргүүцэж байлаа.

Үүнд Түшээ гүн Чагдаржав нар “Хаан эзэн ба улсын цол, оны нэрийг хэвээр батлан тогтоохыг зөвшөөрвөөс чинагши хэлэлцэж болмой” хэмээн хариу эсэргүүцжээ. Оросын төлөөлөгчид Марокко, Бухар, Египет зэрэг улсуудыг үлгэр жишээ болгон “эдгээр орнуудын эзэд нь хэдийгээр мөн орнууд нь хамгаалал дор байвч хуучин хэвээр сүлд, эмир, хан хэмээх цолуудыг хэрэглэсээр”²⁰ буйг тайлбарлахад Хятадын төлөөлөгч: “эдгээр үлгэрүүдийг Гадаад Монгол дор үл таармой” хэмээжээ. Оросын элчингээс хоёр талын дундыг баримтлан: “өөрөө эзэрхэх Монгол” хэмээн бичих санал гаргахад Монголын тал зөвшөөрч, харин Хятадын элчин нилээд уурсаж: “Би үхэвч бээр Гадаад хэмээх үсгийг хасаж чадахгүй”²¹ гэж тас зөрж хурлыг тарааж байсан нь хүртэл харагдана.

Оросын элчин уг асуудлаар байр сууриа илэрхийлэн “Хэрэв Хятад тохирохгүй будваас хэмжээтэй эзэрхэх эрхийг ч алдагдах буй за. Монголын тухай өчүүхэн хэрэгт бидний хоёр улс найрамдлыг эвдэж яахин болмой. Харин ч Гадаад Монголыг олон улсын дунд ямар зэрэг дэвээр байхыг тодорхойлох нь манай Орос улс дор Хятадаас бага үгүй чухал болгон санагдмой. Нэгэнт Орос Хятад хоёрын илтгэн гаргах бичиг дор гарын үсэг зурсан тул үүгээр Оросоос Гадаад Монголын өөртөө эзэрхсэнийг хүлээсэн болмой”²² гэсэнд Хятад этгээд баахан суларч, хэлэлцээрийн хурлыг хэвээр нээн хэлэлцэхэд Хятад, Монгол

хоёрын төлөөлөгчид баахан маргалдаж, Оросын элчин дундыг барьж зуучилсны эцэст “Монголын Богд хааныг Гадаад Монголын маш арилсан Богд Жавзандамба хутагт хаан” хэмээхээр тогтсон (зөвхөн хаан хэмээх үгийг нотлохын тулд Түшээт ханы хуучин тамгыг Хүрээнээс авчруулж байжээ) ба мөн зөвхөн Хятад лугаа харилцах албан бичигт “Дундад Иргэн Улсын оны тоог хэргэлж, Монголын арван хоёр жил, сарны улирлыг хавсран бичих” ба Монгол улс дотор болон Орос лугаа харилцах бичиг үйлдэхэд улсын цол, Олноо өргөгдсөн хэмээх оныг хэвээр хэрэглэхээр “тохиролцжээ”. Энэ бүгд нь монголын төлөөлөгчид, түүний дотор Түшээ гүн Чагдаржавын ухаан, тэвчээр, нөр их зүтгэлийн бага боловч ололт байсан гэж үзэж болно.

Монголын төлөөлөгчдөөс Монголын засаг, улсын нэр, хааны нэрээ хамгаалж, Хятадын төлөөлөгчдийн өөрийн дангаар ноёрхох эрхийг бүрэн тогтооход чиглэсэн саналыг эрс эсэргүүцэн, хоёр гүрний хуйвалдааны эсрэг байрнаасаа хөдлөхгүй байсаных нь төлөө Хятад, Оросын төлөөлөгчид Монголын засгийн газрын эрх барих төлөөлөгч Чагдаржавын хамтран зүтгэгч Да лам Дашжавыг “улс төрийн талаар мөчид”, гишүүн Манлай ван Дамдинсүрэнг “дайн ч түрэмгий” хэмээн шүүмжлэн буцаахад хүргэжээ.

Хаант Орос, Хятадын төлөөлөгчид, ялангуяа хятадын эрх баригч Монголыг “улс” хэмээн томъёолохыг эрс эсэргүүцэж, “хэрэв улс хэмээн бичвээс Хятадаас салсан болох ба Орос улс залгихад хүрнэ” хэмээн зүтгэн, гэрээний хятад, монгол үсгээр бичсэн хувь дор баримталбал зохих үндсэн франц үсгийн хувиас гажиж, Оросын төлөөлөгчдийн тэргүүн Миллер “Хэрэв миний үгийг эс зөвшөөрвөөс гэрээг Монгол үсэг үгүй батлан тогтоох буюу эсгүүл Орос, Хятад хоёр өөрчлөн хэлэлцэн тогтоож болмой. Тэр цаг дор үүнээс сайн болох буюу” гэхчилэнгээр Монголын төлөөлөгчдийг ихэд айлган сүрдүүлэх оролдлого нэг бус удаа гарч байсан ч Чагдаржав нар алсын хараа, ноён нуруу, уужуу тайван сэтгэл, нарийн ухаан, тэвчээр зориг зааж давж гарч чадсан юм.

Хэлэлцээрийн нэгэн тэмдэглэлд “Түшээт ван гадаа гаран зогсож буцаж болох эсэхийг зарлигаар гуйх ажаамуу” хэмээсэн нь ямар их дарамт өөрийн биеэр амсаж байсаныг илтгэнэ.²³

Мөн Монголын засгийн хэрэг шийтгэх газрыг албаны газар өөртөө эзэрхсэнийг өөрөө засах хэмээн хятад үсгийн ёсоор бичвээс зохино гэж Хятад, Орос элчин дүрэмдэж, баахан маргалдсаны эцэст “Орос элчин Хятад лугаа өөр газар баахан хэлэлцээд Монгол үсэг дор засгийн хэрэг шийтгэх газрыг хэвээр бичсүгэй, хэмжээтэй эзэрхэх эрх ба өөртөө эзэрхсэн хэмээх үсгийг цөм франц улсын үсэгний аялгуугаар бичсүгэй” хэмээн тохиролцсон нь Монголын эрх барих Чагдаржавын оруулсан хувь нэмэр мөн буй за.

Энэхүү гурван улсын гэрээний үеэр Монголын хил хязгаарын асуудлыг хэлэлцэхэд Чагдаржав нар үнэхээр мэдлэг чадвар гаргаснаар эдүгээгийн Монголын нутагт Дарьганга, Цагаан түнх зэрэг газрыг оруулахгүй байх гэсэн Хятадын төлөөлөгчдийн санаархлыг тас цохиж чадсан юм. Ийнхүү гурван улсын гэрээгээг Монголын хил хязгаарын асуудлыг тодорхойлон заасан нь хожим 1945 онд Дэлхийн хоёрдугаар дайны төгсгөлийн үеэр Англи, Америк, Орос гурван их гүрний тэргүүн нарын уулзалтаар “Гадаад Монголын статусвог одоогийн байгаа хилээр хүлээн зөвшөөрөх” үндэс болсон бизээ. Хиагтын гэрээгээр Монголын Хятад лугаа нийлсэн хилийг нарийвчлан тогтоох асуудлыг гэрээ тогтоосноос хойш 2 жилийн дотор 3 этгээдийн төлөөлөгчдийг оролцуулан шийдвэрлэхээр заасан ч талаар өнгөрсөн болохыг бид мэднэ.

Энэ бүхэн бол Чагдаржав нар ухаан, ноён нуруу, тэвчээ, алсын хараатай байсаны хүчинд хоёр их гүрний шахалтантан дор бараг 9 сар шахам тэмцэлдэж, эцэст нь өргөн автономи эрхтэй улс байхыг хоёр хөршөөрөө хүлээн зөвшөөрүүлж чадсан хэрэг юм. Мөн тухайн үедээ гурван улсын гэрээгээр тогтоосон Монголын байдлыг Монголын төрийн зүтгэлтнүүд хэрхэн ойлгож байсаныг дараах баримтаас харж болно. Үүнд: “Гадаад хэргийг бүгд эрхлэн шийтгэгч яамнаас Богд хаанд айлтгасан “Думдад, Орос, Монголын гэрээ бичгийн утга чанарыг тайлбарласан дэвтэр”-т өгүүлэхдээ: “хүчирхэг нь буурайгаа дарлан элдэв эрх ашгийг булаан эзэрхэхийг хичээх нь олон улс нийтэд бүхий далсан суртал мөн тул эс болгоомжилбоос эс болох... Энэхүү гэрээ бичгийн гол утга болбоос бидний улс хэдий Думдад улсын хэмжээтэй эзэрхэхийг хүлээсэн боловч Думдад улсаас бидний дотоод засгийн буй бүхий хэрэгт оролцох эрх огт үгүй...” хэмээн тэмдэглэсэн байна. Өөрөөр хэлбэл Монголын дотоод хэрэгт Хятад оролцохгүй гэсэн үг билээ. Энэ бол бие даасан улсын адилаар өөрийн дотоод бүхий л асуудлыг шийдвэрлэж болохыг орос, хятад хоёроор хүлээн зөвшөөрүүлж чадсан хэрэг юм.

Мөн Оросын дипломатуудын гаргасан сюзеренитет хэмээх үгийн агуулгын тухай Оросын Гадаад явдлын яамны сайд Сазоновоос Хүрээнд суугаа ерөнхий консул Миллерт явуулсан захидалдаа: “Бидний зөвшөөрөн хүлээсэн, Хятадаас Монголын хувьд эдлэх сюзеренитет нь тэр хоёр улсын хоорондын зөвхөн цааз хуулийн холбоо бөгөөд учир нь тэд Монгол улс бүх асуудлын талаар, тэр ч байтугай улс төрийн талаар гадаадтай харилцах эрхийг үгүйсгэхгүй юм”²⁴ хэмээжээ. Харин “Гадаад хэргийг бүгд эрхлэн шийтгэгч яамнаас Богд хаанд айлтгасан “Думдад, Орос, Монголын гэрээ бичгийн утга чанарыг тайлбарласан дэвтэр”-т энэ талаар өгүүлэхдээ: “Гадаад Монгол Думдад улсын сюзеренитетийг хүлээн зөвшөөрснөөр улс төрийн байдлаа алдсан явдал

огт үгүй. Харин ч Думдад, Орос хоёр улстай хамт нийлэн зөвхөн хэлэлцэх чухал эрхийг олж авсан энэхүү гэрээ бичгийг төгсгөж байгуулаад олон улсын дунд өөрийн дотоод засгийн бүх хэрэг зүйлийг өөртөө зэрхэх улс төр болсноо илэрхийлжээ” хэмээсэн байна. Энэ бүхэн бол Монголын улс байх эрхийг орос, хятадын төлөөлөгчид эл гурван этгээдийн гэрээ хэлэлцээрээр бүр мөсөн хориглож чадаагүй болох нь харагдаж байгаа юм. Үүнд мэдээж Монголын тухайн үеийн төрийн зүтгэлтнүүд, түүний дотор эхнээс эцэсий нь хүртэл тэргүүлэх үүрэгтэй байсан түшээ гүн Чагдаржавын нөр их ухаан, хүчин чармайлт, мятаршгүй тэмцэл, олон зууны турш үеэс үе дамжин ирсэн залгамж чанар хадгалсан түүхэн уламжлалаа өвлүүлэх чин эрмэлзэл нөлөөлсөнийг бодит байдлаар шашдирт тэмдэглэж дуурсах нь нэн зохилтой хэмээн санана.

Эл гурван улсын гэрээгээр Хятадын сюзеренитет бүхий автономит Монгол нь өөрийн нутагт хятад цэрэг оруулахгүй, өөрийн үндэсний засгийн газар, цэрэг армитай байх эрх авсан юм. Энэ бол өөрийн тусгаар тогтнолоо цаашид бүрэн утгаар нь олж авах, Монгол төрөө сэргээн мандуулах тэмцлийн нэгэн хэлбэр болсон хэмээн үзэж байна.

Хэлэлцээрийн үеэр “Богд эзэн хаан, Улсын Эх дагина нартаны харштай гариг Лхагва, Бямбыг цээрлэж”, зарим тохиолдолд өвчнөөр шалтгаацин хойшлуулж байсан нь асуудлыг нухацтай, өөрийн ашиг сонирхолд нийцүүлэх үүднээс сэдсэн монголын төлөөлөгчдийн тэргүүн Чагдаржавын нэг мэх байсан буй за.

Ийнхүү гурван этгээдийн хэлэлцээр бүтэн есөн сар үргэлжилсэний дараа Монгол улсын Олноо Өргөгдсөний тавдугаар он буюу хөхөгчин туулай жил зуны тэргүүн сарын 25-ны нохой цагт Европын 1915 оны тавдугаар сарын 25-нд Хятад улсыг төлөөлж Би Гуй Фан, Чень Лу, Хаант Оросыг төлөөлж А.Миллер, Гадаад Монголыг төлөөлж Ширнэндамдин, Чагдаржав нар гарын үсэг зурж, 3 этгээдийн гэрээ²⁵ батлан тогтоогоод бичиг зүйлсийг солилцон эл хэргийг дуусгасан байна.

Хэлэлцээрийн төгсгөлд Гэрээнд тамга дарах тухай асуудал гарахад, Орос элчин “Монгол улс” хэмээх зэрэг үсэг орсон Монголын бүрэн эрх барих сайдын тамгыг хэргэлж болохгүй хэмээн эсэргүүцсэн учраас Монголын төлөөлөгчид хэрэглэх их, бага хоёр тамгын нэгийг Хиагтад Орос дарханаар үйлдүүлэхээр болж, нөгөөг Хүрэннээс үйлдэж ирүүлэхээр тохиролцож байсан байна.

Гурван улсын хэлэлцээрт оролцогчдын зүтгэлийг Богд хаантнаас сайшаан тэмдэглэж, Чагдаржавт зарлигаар үе улиран засаг хошой чин вангийн хэргэм шагнаан хүртээж байжээ.²⁶

Төгсгөл болгох нь

Түүхэнд улс хооронд болсон хурал дотроос хугацааны хувьд хамгийн удаан үргэлжилсэн Венийн бага хурлын (яг нэгэн зууны өмнө болсон) Азийн хувилбар болсон эл Гурван улсын Хиагтын хэлэлцээр нь урьд нь улс төрийн шалтгаанаар түүний эерэг, сөрөг тал тэр бүр судлаач, өргөн олон түмэнд хүрч бодит байдлаар дүгнэгдээгүй, түүнд оролцсон монголын төлөөлөгчдийн үйл ажиллагаа, нөр их зүтгэлийг умартах шахам явж ирсэн байдлыг цаашид зогсоох үүднээс өчүүхэн молхи судлаач өөрийн судалгаандаа түшиглэн дараах дүгнэлтүүдийг хийхийг оролдлоо. Үүнд

-Хиагтын эл хэлэлцээрт Монгол улс Орос, Хятадын нэгэн адил олон улсын тогтсон хууль ёсны дагуу бүрэн эрх бүхий нэгэн субъект нь байж, хэлэлцээрийн оролцогч нэгэн талын хувьд түүний бүрэн эрх барих Төлөөлөгч Чагдаржав, Дашжав, Ширнэндамдин нарын монголоо хэмээсэн сэтгэл өвөрлөж, өөрийн оюун ухаан хүч чадлаа үндэснийхээ тусгаар тогтнолын төлөө зориулсан үйл ажиллагааг үнэн бодит байдлаар дүрслэн харуулж, тэдний үйл хэргийг түүх шашдирт зохих байр суурийг эзлүүлэх нь зүйтэй мэт санагдана.

-1915 оны энэхүү гэрээ нь Монгол улсын хувьд Чагдаржав нарын санаачилсан урд хөршөөсөө салан тусгаарлах 1911 онд эхэлсэн үйл явцаа улам бэхжүүлэх алхам болсон бөгөөд харин ч олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх эхлэл болсон хэмээн үзүүштэй. Хэдийгээр гэрээнд Монгол нь Хятадын нэгэн хэсэг болохыг ёс төдий заасан боловч эдийн засаг, улс төрийн эрх ашгийн хуваарилалт Оросын талд давуутай шийдвэрлэгдсэнийг олон зүйлээр харж болно.

- Түүний тухай Г.Навааннамжил авгай дурсан бичихдээ: «Монгол бичигт гарамгай сайн, хашир томоо бүхий бөгөөд ард олонд хөнгөн зөөлөн зантай, тайван, хэн юу л гэвэл «за» гэж явдаг» хэмээжээ.²⁷ Харин Оросын нэрт эрдэмтэн Е.М.Даревская 1911 оны Монголын үндэсний хувьсгалын удирдагчдын нэг Г.Чагдаржавт өгсөн үнэлэлтдээ: «Тэр бол эрүүл ухаантай дэвшилтэт үзэлтэй нэгэн байсан» хэмээсэн²⁸ нь тун онож хэлсэн үгс шиг санагдана. Тиймээ, Гадинбалын Чагдаржав абугай бол Монголын түүхэнд өөрийн эзлэх байр суурьтай, 1911 оны монголын үндэсний хувьсгалыг санаачлагдын нэг, удирдан зохион байгуулалцсан төрийн түшээ байсан юм. Тэрбээр төрийн хэрэгт ул суурьтай хандаж, Монголынхоо тусгаар тогтнол, эрх чөлөөний төлөө тэмцэлд нэгэн үзүүрт сэтгэлээр хүчин зүтгэж, өөрийн бүхий л ухамсарт амьдралаа Монгол үндэс угсаагаа хойч үедээ өвлүүлэх үйл хэрэгт тэр чигээр нь зориулсан нэгэн билээ. Түүний нэр төрийг түүх шашдирт тэмдэглэн, түүх дурсгалыг нь Монголын түмэн олон хүндэтгэж байх учиртай төрийн зүтгэлтэн даруй мөн бүлгөө.

ИШЛЭЛ, ЗҮҮЛТ

1. Г.Навааннамжил Өвгөн бичээчийн өгүүлэл УБ.,1959, 186 дахь тал
2. С.Г.Лузянин “1911-1917 оны Орос- Монголын худалдаа эдийн засгийн харилцаа” өгүүлэл., - “Страны Востока в политике России В XIX начале XX вв. Ир.1986. с.35-36”
3. Л.Дэндэв Автономит Монгол улсын үеийн онцлог баримт бичгүүд 1945 он, 85 дахь тал
4. Монгол улсын Автономи хэмээх өөртөө эзэрхэн засах эрхт засгийн үеийн үнэнхүү явдал чухам байдал, чухал учрыг тэмдэглэсэн товч өгүүлэл хэмээх түүх бичиг О.Батсайханы эмхтгэсэн УБ., 1992он, 6 дахь тал
5. Монгол улсын Автономи хэмээх өөртөө эзэрхэн засах эрхт засгийн үеийн үнэнхүү явдал чухам байдал, чухал учрыг тэмдэглэсэн товч өгүүлэл хэмээх түүх бичиг О.Батсайханы эмхтгэсэн УБ., 1992он, 711 дахь тал
6. Магсар хурц Монгол улсын шинэ түүх УБ., 1994 он, 10-15 дах тал
7. Үндэсний төв архив. Ф.А2, т.1, х.н,3 х.18
8. Үндэсний төв архив. Түүхийн баримтын төв, ф.А-4, т.1,х.н.26, х.3)
9. Үндэсний төв архив, ф.А-4, т.1,х.н.26, х.4
10. Хорьдугаар зууны Монгол УБ.,1995., УБ.16 дахь тал
11. Сборник дипломатических документов по Монгольскому вопросу (23 авг.1912 – 2 ноября 1913) СПбетербург, 1914, с.32
12. З.Лонжид Монгол улсын санхүүгийн албаны түүх (1911-1921) УБ.,2000., 12 дэх тал
13. С.Чулуун -1911 оны үндэсний хувьсгалын удирдагчдын нэг Г.Чагдаржавын улс төрийн үйл ажиллагааны тухайд – МУИС ийн Оюутны эрдэм шинжилгээний бүтээлийн эмхтгэл Д-2, УБ.,1999 он, 50 дах тал
14. Зарлигаар тогтоосон Монгол улсын шашдир 1 боть., УБ., 1997., 18 дах тал
15. Хятад, Орос, Монгол гурван улсын 1915 оны Хиагтын гэрээ Өдөр

тутмын эмхтгэл, Баримт бичгийн эмхтгэл, Эмхтгэж, тайлбар бичсэн
О.Батсайхан, УБ., 1999 он, 23 дахь тал

16. Мөн тэнд 38 дахь тал

17. Хятад, Орос, Монгол гурван улсын 1915 оны Хиагтын гэрээ Өдөр
тутмын тэмдэглэл Баримт бичгийн эмхтгэл О.Батсайханы эмтгэсэн УБ.,
1999 он, 96 дахь тал

18. Үндэсний төв архив ф.4, д.1, х.н.38 126 дах тал

19. Хятад, Орос, Монгол гурван улсын 1915 оны Хиагтын гэрээ Өдөр
тутмын тэмдэглэл Баримт бичгийн эмхтгэл О.Батсайханы эмтгэсэн УБ.,
1999 он, 145

20. Мөн тэнд 189 дэх тал

21. Мөн тэнд 223 дах тал

22. Мөн тэнд 205 дах тал

23. БНМАУ-ын түүх 2 боть., УБ., 1969, 555 тал

24. Сборник дипломатических документов по Монгольскому вопросу.,
Санкт- Петербург, 1913 г., с.90

25. Хятад, Орос, Монгол гурван улсын 1915 оны Хиагтын гэрээ (Өдөр
тутмын тэмдэглэл) Баримт бичгийн эмхтгэл УБ., 1999., 538 дахь тал

26. Үндэсний төв архив., Ф.А2, т.1, х.н.108, 5 дах тал

27. Г.Навааннамжил Өвгөн бичээчийн өгүүлэл УБ., 1956., 100-103
дах тал

28. Е.М.Даревская Три портрета – три судьба Исторические очерки
УБ., 1997., 57 дахь тал